



ХОВД АЙМГИЙН ЦЭЦЭГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА *Б.ТАНБАЯР*

ЦЭЦЭГ СУМЫН ХӨШӨӨТ БАГТ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦЭЙ ХУДАГ ГАРГАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

*ХОАУСЗДХАГ/202301002*

2023.03.21

Цэцэг нуур

1	Төсөл боловсруулах үндэслэл	Цэцэг сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 7/04 тоот тогтоолоор батлагдсан 04 дүгээр хавсралтад тусгагдсан орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээний 1.3-д тусгагдсаныг үндэслэл болгон.
2	Барилгын ажлын нэр төрөл /байршил/	Ховд аймаг Цэцэг сум, Хөшөөт баг
3	Барилга барих газрын хэмжээ /зориулалт/	Худаг гаргах ажил
4	Төслийн захиалагч	Ховд аймгийн Цэцэг сумын Засаг даргын Тамгын газар
5	Ажиллах горим	24 цаг
6	Барилгын үндсэн бүтэц материал	<p><b>Ерөнхий зорилго:</b> Ундны усны хангамж сайжруулах</p> <p><b>Худгийн барилга:</b> MNS6088:2010 БНБД81-06-06 БНБД81-10-06 БНБД51-02-05-д заасан шаардлага үзүүлэлт хангасан байна.</p> <p><b>-Өрөг бүтэц:</b> БНБД51-02-05</p> <p><b>-Дээвэр:</b> БНБД31-02-03</p> <p><b>-Шал:</b> БНБД31-12-08</p> <p><b>-Цонх хаалга:</b> MNS5830:2008 MNS0531:2002 шаардлага хангасан байна.</p> <p><b>Худгийн байр:</b> Бетонон гадна довжоо бүхий тэнхлэгээрэй 3.4*2.8м, 18мкуб эзэлхүүнтэй шугаман суурь бүхий М100 марктай 380мм зузаан тоосгон ханатай төмөр сараалжин хамгаалалт бүхий вакум цонх, бетонон шалтай, модон шувуун хуруун хучилттай, гипсэн хавтан пүүжин таазтай байна.</p> <p><b>Худгийн онгоц:</b> Мал услах онгоц нь 6м-ээс багагүй урттай 400мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетоноор хийсэн байна.</p> <p>Мал услах онгоцны 2 талд 1м урттай, 0.5м өндөртэй цементэн хавтан суулгах эсхүл уртын дагууд 1м-ийн өргөнтэй бетон цутгаж мал услалт хийх. Мал услах онгоцны ёроол нь ус юүлэх налуутай байна.</p> <p><b>Гэрэлтүүлэг:</b> Гэрэлтүүлгийг сонгохдоо биед хортой бодис агуулагдаагүй байгаль орчинд сөрөг нөлөөгүй стандарт нормд нийцсэн бат бөх байх шаардлагатай.</p> <p><b>Дотор засал:</b> Ханыг сайжруулсан шавардлагаар шавардаж хөрсжүүлэлт грунт хийсний дараа цайвар ногоон өнгийн эмүльсэн будгаар 2р удаа мөн дүүжин таазанд грунт хийсний дараа цагаан өнгийн эмүльсэн будгаар будна.</p> <p><b>Гадна засал:</b> М100 маркын 380мм зузаантай ханыг гадна талаас нь гоёлын өрлөгөөр /шоов гаргаж/ гүйцэтгэнэ.</p> <p>Худгийн барилгаас 6м-ийн алсласттай эрүүл ахуй ариун цэврийн бүс тогтоож, худгийн барилгыг 1м-ийн өндөртэй</p>